

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

**МОНГОЛЫН АЛТАН АЯЛАЛ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ**



Д.ХУЛАН

**УЛААНБААТАР ХОТЫН БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, БОГДХАН УУЛЫН ДАРХАН
ЦААЗАТ ГАЗРЫН ХЯЗГААРЛАЛТЫН БҮС, ЗАЛААТЫН АМАНД БАЙГУУЛАХ
"МОНГОЛЫН АЛТАН АЯЛАЛ" ХХК-ИЙН "АЯАН ЗАЛААТ АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР ТӨСӨЛ" 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2871777/**

БОЛОВСРУУЛСАН:

"АЯАН ХОТЕЛС ЭНД РЕСОРТС" ХХК-ийн

ХАБЭА-н мэргэжилтэн Б.Батболд /........../

2025

[Date]

1

АГУУЛГА

ОРШИЛ.....	3
НЭГ. ҮЙЛДВЭРИЙН / ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ НӨХЦӨЛ	11
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ....	13
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	18
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
НАЙМ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	28
АРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТ	29
АРВАН НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	30
АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА,ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	32
АРВАН ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	34
АРВАН ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ НИЙТ ЗАРДАЛ.....	34

ОРШИЛ

“Монголын алтан аялал” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Аян Залаат” аялал жуулчлалын цогцолбор төсөл нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн Залаатын аманд, нийт 11.3 га талбайд хэрэгжихээр төлөвлөгдөж, төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт, тодотголын тайлан 2025 онд батлагдсан болно. Энэхүү нарийвчилсан үнэлгээ нь төслийн байршлын онцлог, тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, барилгын бүтээн байгуулалтын хэмжээнд тулгуурлан төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны өмнө хүлээх үүрэг, шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг тодорхойлсон үндсэн баримт бичиг юм.

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (цаашид БОМТ гэх) нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 1 болон 3 дугаар хавсралтын шаардлагын дагуу боловсруулагдсан бөгөөд БОМТ-ийн бүтэц, арга зүй, тайлагналын шаардлагыг бүрэн хангасан болно.

Төлөвлөгөө нь 2026 онд хэрэгжих төслийн үйл ажиллагааны цар хүрээ, тухайн хугацаанд бий болох байгаль орчинд нөлөөлж болзошгүй эрсдэлүүд, мөн Нарийвчилсан үнэлгээнд үндэслэн тодорхойлогдсон хамгаалалт, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг уялдуулан хэрэгжүүлэх зорилготой. БОМТ нь зөвхөн 2026 оны төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамаарах зохицуулалт, төлөвлөлт, хэрэгжилтийн хяналтын үзүүлэлтүүдийг багтаана.

2026 оны энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах суурь баримт бичгүүдэд тулгуурлан боловсруулагдсан:

- “Аян Залаат” төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт, тодотголын тайлан (2025)
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон ДЦГ-ын бүсийн дэглэм
- Байгаль орчны багц хууль, стандартууд
- Байршлын суурь нөхцөл байдлын судалгааны мэдээлэл

Төлөвлөгөөний хэрэгжилт нь төслийн байгаль орчны гүйцэтгэлийн үндсэн шалгуурын нэг бөгөөд төслийн үйл ажиллагааг хариуцлагатай, тогтвортой, байгальд ээлтэй байдлаар хэрэгжүүлэх дотоод хяналтын чухал хэрэгсэл болдог.

НЭГ. ҮЙЛДВЭРИЙН / ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. **Төслийн нэр:** “Аяан Залаат” аялал жуулчлалын цогцолбор төсөл

1.2. **Төсөл хэрэгжүүлэгч:** “Монголын алтан аялал” ХХК

- Улсын бүртгэлийн дугаар: 9011201035
- Регистрийн дугаар: 2871777
- Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19-р хороолол, “Монголын алт (МАК)” ХХК-ийн төв байр
- Утас: 7011-0969

1.3. **Төслийн байршил:** Төсөл нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн Залаатын аманд, нийслэлийн төв цэгээс 6 км зайд байрлана. Байршлын онцлог нь тусгай хамгаалалттай бүсийн дэглэмд хамаарах тул төслийн төлөвлөлт, хамгаалалтын арга хэмжээ өндөр шаардлагатай.

Газрын гэрчилгээний дугаар	Талбайн хэмжээ /га/ 	Булангийн цэгүүдийн дугаар	Солбицол		Цэгүүд
			Х	Ү	
11 га талбай					
2011/03	11.3	1	5307328.474	648526.635	1-2
		2	5307243.637	648523.064	2-3
		3	5307159.552	648501.059	3-4
		4	5306918.319	648514.421	4-5
		5	5306710.418	648494.334	5-6
		6	5306738.927	648412.410	6-7
		7	5306735.059	648382.155	7-8
		8	5306895.944	648317.107	8-9
		9	5306956.321	648218.274	9-10
		10	5307104.157	648359.530	10-11
		11	5307161.263	648351.995	11-12
		12	5307114.482	648257.376	12-13
		13	5307161.119	648255.620	13-14
		14	5307182.964	648289.986	14-15
		15	5307186.889	648339.488	16-15
		16	5307298.235	648328.268	16-17
		17	5307315.354	648424.149	17-18
		18	5307326.291	648429.174	18-1

Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн солбицол

1.4. **Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт:** Төсөл нь өндөр зэрэглэлийн аялал жуулчлалын цогцолбор байгуулах бөгөөд дараах үндсэн байгууламжуудыг багтаана.

- 16 давхар гэр бүлийн зориулалттай зочид буудал
- Клубхаус – 11,661 м²
- Галерей шоп – 1,123 м²
- Спорт комплекс – 3,201 м²
- 4 төрлийн сууц (А, В, С, D) – нийт 8,378 м²
- Барилгажих нийт талбай: 20,040 м²
- Барилгын хийц: төмөр бетон араг бүтээц, зоорьтой, 3–16 давхар
- Ашиглалтад орсноор 200 ажлын байр шинээр бий болно.



Зураг 1. Төслийн харагдах байдал

1.5. **Инженерийн дэд бүтцийн шийдэл:** Тус байгууллага нь дэд бүтцийн төлөвлөлтийг дараах байдлаар шийдвэрлэхээр төлөвлөсөн байна.


Ангилал	Нэршил	Тайлбар
Цахилгаан	РП 10кВ	Залаат 110/35/10 дэд станцаас 4 ширхэг Ф240 өндөр хүчдэлийн ЦДКШ-аар 2х1600кВА ХТП

Халаалт	K2000 халаалтын зуух /Хорват/	Сайжруулсан шахмал түлшний халаалтын зуух, Циклон-РС11 утааны шүүлтүүртэй.
Цэвэр ус	Гүний худаг	Гүний 1 худаг
Бохир ус	ShinSung KongYoung /Солонгос/	110 м3 бохир усны хүчин чадалтай септик танк бүхий нян устгагчтай цэвэрлэх байгууламж

Хүснэгт 2. Дэд бүтцийн төлөвлөлт, шийдэл

1.5.1. Дулаан хангамж

1. Уурын зуух ашиглахгүйгээр халаалтын систем шийдсэн хувилбар судлагдсан
2. Хатуу түлшээр ажиллах STAR K2000S циклон шүүлтүүртэй зуух төлөвлөсөн
3. Өндөр ашигт үйлийн коэффициент



Зураг 2. Халаалтын зуухны зохион байгуулалтын зураг

Утга	Чийг (W _{ad}) %, ихгүй	Үнслэг (A _{ad}) %, ихгүй	Дэгдэмхий (V _{ad}) %, ихгүй	Хүхэр (S _{ad}) %, ихгүй	Илчлэг (Q _{ad}) ккал/кг, багагүй	Бат бэх
“Монголын алтан аялал” ХХК-ийн зууханд ашиглаж буй мидлинг	1,16	20,71	18,01	1,00	6615	-
MNS 6226:2011 Стандарт утга: Баяжуулсан нүүрс	<6	<28	<26	<1.3	>5500	-

Хүснэгт 2. Техникийн шинжилгээний дүн

Үзүүлэлт	NOx мг/нм ³	SOx мг/нм ³	COx мг/нм ³	TSP мг/нм ³
Хэмжилтийн үр дүн	168	611	2601	183
<i>MNS 5216. 4.2 MBт хүртэл чадалтай ус халаах зуухны стандарт</i>	<i>450</i>	<i>800</i>	<i>5000</i>	<i>600</i>


Хүснэгт 3. Шинжилгээний үр дүн

1.5.2. Ариутгах татуурга

1. Бохир ус цэвэрлэх байгууламжтай
2. Зөвшөөрөгдөх хэмжээний цэвэршүүлэлттэйгээр байгалд нийлүүлэх шийдэл



Зураг 3. Халаалтын зуухны зохион байгуулалтын зураг



Зураг 4. Цэвэрлэх байгууламжийн технологи ажиллагааны бүдүүвч


Үзүүлэлтүүд	Нэгж	Хэмжээ
-------------	------	--------

Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, БХХ ₅	мг/л	220
Умбуур бодис	мг/л	240

Хүснэгт 4. Бохир усны чанарын үзүүлэлт

Үзүүлэлтүүд	Нэгж	Хэмжээ	Төслийн үзүүлэлт
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, БХХ ₅	мг/л	20	15
Умбуур бодис	мг/л	30	20


Хүснэгт 5. Цэвэрлэсэн усны чанарын үзүүлэлт




Зураг 5. Цэвэрлэх байгууламжийн технологийн схем

1.5.3. Усан хангамж

1. Усны эх үүсвэр: Гүний худгийн ус
2. Өдөрт шаардагдах усны хэрэглээ: БОННУ-д тодорхойлсон тооцоотой (БОННУ-ийн 2.5)



Зураг 6. Гүний худгийн байршлын зураг



Зураг 7, 8 Гүний худгийн байршлын зураг

№	Үзүүлэлт	Зориулалт	Хүчин чадал /хүн/жил/	Ажиллах хоног	Норм /м³/	Хоногийн усны хэрэглээ (м³/хон)	Жилийн усны хэрэглээ (м³/жил)
1.	Ахуйн хэрэглээ	Ресторан, зочид буудал	Жилд 95100 хүн	365	0.2	~ 52.1	19020.0
2.		Амралтын өрөө	Жилд 8970 хүн	365	0.2	~ 4.92	1794.0
3.		Алжаал тайлах өрөө	Жилд 4755 хүн	365	0.2	~ 2.6	951.0
4.		Цогцолборын ажилчид	200 хүн	365	0.2	~ 40	14600.0
5.	Ногоон байгуулам жийн усалгаа	Суулгац /Мод/	270 ш	60	0.04	~ 10.8	648.0
6.		Зүлэгжүүлэлт	9205 м²	60	0.004	~ 36.8	2209.2
Нийт дүн						~ 147.22	39222.2

Хүснэгт 6. Төслийн технологийн болон ахуйн жилийн усны хэрэглээ

1.5.4. Цахилгаан хангамж, холбоо

1. Төлөвлөгдсөн дэд станц, ил хатуу болон кабель шугамын шийдэл (БОННУ–ийн 2.7, 2.8)

1.6. Үйл ажиллагааны онцлог

1. Зочид буудал, клубхаус, спорт, үйлчилгээний иж бүрэн цогцолбор
2. Өндөр бүтээн байгуулалттай тул барилгын үеийн ачаалал их
3. Тусгай хамгаалалттай бүсэд байрлах тул байгаль хамгааллын шаардлага өндөр
4. Хог хаягдлын зохистой менежмент, бохир усны хяналт шаардлагатай
5. Нийтийн хэрэглээний ус, дулаан, цахилгааны найдвартай ажиллагаа чухал

1.7. Ажиллах ажилтны тоо

1. Барилгын үе: улирлын болон хугацаатай 100–200 ажилтан
2. Ашиглалтын үе: 200 байнгын ажилтан (БОННУ–ийн Оршил → 200 ажлын байр шинээр бий болно)

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ НӨХЦӨЛ

2.1. Байршлын ерөнхий нөхцөл: Төсөл нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн Залаатын аманд, нийслэлийн төвөөс баруун урагш 6 км зайд байрлана. Байршлын хувьд нийслэлийн ногоон бүсийн орчим, экологийн эмзэг, хамгаалалтын дэглэм өндөртэй газар нутгийн ангилалд орно.

2.2. Газрын гадарга, геоморфологи:

Талбай нь уулын хормой, голын хөндийн залгаа хэсэгт байрлах ба:

- Газрын гадарга уулын бэл, нарийн амны хэлбэртэй, тодорхой хэмжээний налууг агуулдаг
- Хөндийн хэлбэр, уулсын залгаа газрын геоморфологийн хувьд ус зайлуулах сувгийн нөлөө ихтэй
- Үерийн далан, ус хуримтлал үүсэх өндөр эрсдэлтэй бүс биш боловч уулын амны хэлбэрээс шалтгаалан усны урсацын чиглэл тодорхой байдаг. Эдгээр нь барилгын үеийн хөрсний эвдрэл, ус зайлуулах зохион байгуулалт, ногоон байгууламжийн төлөвлөлтөд чухал нөлөөтэй.

2.3. Хөрсний нөхцөл:

БОННУ-д тусгагдсанаар:

- Хөрсний бүрхэвч нь бор хөрсний хэв шинжтэй
- Хөрсний үржил шимт давхаргын зузаан харьцангуй нимгэн
- Гадаргын эвдрэлд өртөмтгий, барилгын ажлын үед хөрсний цэврүүжилт, шилжилт үүсч болзошгүй
- Эвдрэл үүссэн тохиолдолд нөхөн сэргээлт хийх шаардлагатай бүсэд хамаарна.

2.4. Агаарын чанар:

2.4.1. Байршил нь уулын нарын ам тул:

- Салхи, агаарын солилцоо байгалийн горимоор жигд бус
- Халаалтын улиралд орчны агаарын бохирдол Улаанбаатар хотын ерөнхий түвшинд нөлөөлөгддөг
- Төслийн хувьд хатуу түлшээр ажиллах дулааны зуух төлөвлөсөн бөгөөд циклон шүүлтүүр ашиглах нь НҮ-т тодорхой

2.4.2. Агаарын чанарт нөлөөлөх хүчин зүйлс:

2.1 Тоосжилт (барилгын үе)

2.2 Дулааны зуухны яндангийн утаа (ашиглалтын үе)

2.3 Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөн

2.5. Усны нөхцөл

2.5.1 Гадаргын ус:

Талбай нь уулын амны хэлбэртэй тул:

- Байнгын урсацтай гол, горхи байхгүй
- Хаврын хайлмаг ус болон борооны үеийн түр хугацааны урсац үүсдэг
- Инженерийн шийдэлд ус зайлуулах системийг сайтар төлөвлөх шаардлагатай

2.5.1 Газрын доорх ус

- Усны эх үүсвэр нь гүний ус
- Гүний усны нөөц, хэрэглээний тооцоо БОННУ-д тусгагдсан
- Газрын доорх ус бохирдохоос сэргийлэх зорилгоор СБОЦБ заавал ашиглах шаардлагатай

2.6. Ургамлан нөмрөг:

Байршлын ургамлан нөмрөг нь:

- Уулын бэл, хуурай хээрийн ургамлын бүлгэмд хамаарах
- Хавтгай үндэст өвс, сөөг зонхилдог
- Дархан цаазат газарт хамаарах тул ургамлын үсэрхийлэл, тасалдалд мэдрэмтгий
- Нэн ховор ургамлын судалгаагаар тусгай хамгаалалттай төрөл илрээгүй ч НҮ-д “болзошгүй нөлөөлөлтэй бүс” гэж тодорхойлсон

2.7. Амьтны аймаг:

Байршлын онцлогоос шалтгаалан:

- Уулын нутгийн нийтлэг хөхтөн: туулай, үнэг, зэрлэг муур
- Шувууд: бялзуухай, харцага зэрэг уулын амны орчинд дасан зохицсон зүйлүүд
- Тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэмийн улмаас амьтны амьдрах орчны нүүдэл хөдөлгөөнд анхаарах шаардлагатай
- НҮ-д зэрлэг амьтдын тасалдалд өртөх эрсдэл дунд зэргийн түвшинд үнэлсэн байна.

2.8. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм:

Төсөл нь Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсэд байрладаг. Энэ бүсэд:

- Барилга байгууламж барих, газар ашиглах нь тусгай зөвшөөрөлтэй.
- Байгаль хамгаалах нэмэлт дэглэм мөрдөнө.
- Хог хаягдал, бохир ус, газар ашиглалтын шаардлага өндөр.
- НҮ-ийн 3.4.9-д тусгай хамгаалалттай бүсэд үзүүлэх нөлөөг тодорхой үнэлсэн.

2.9. Нийгэм, эдийн засгийн нөхцөл

- Төсөл хэрэгжүүлэх талбайд байнгын хүн оршин суудаггүй.
- Ойр орчимд аялал жуулчлалын үйлчилгээний хэрэгцээ өндөр.
- Төслийн үр дүнд 200 байнгын ажлын байр бий болно.
- Нийслэлийн аялал жуулчлалын хөгжлийн зорилттой уялдана.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

2.1 Төсөлд ашиглагдах Богдхан уулын ДЦГ-ын орчны бүс нутгийн онцлогт тулгуурлан, байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгалийн хам бүрдлүүдтэй уялдуулан тодорхойлсон хүснэгтийг доор үзүүлэв.

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж, чанар, өртөгдлийн байдал
Нэг. Агаар орчин			
1.1.	Агаарын чанарт нөлөөлөх	Уурын зуухнаас гарах утаа	Улирлын чанартай, тархах хүрээ хомс
1.2.	Ахуйн хаягдал	Дулааны улиралд ахуйн хаягдал удаан хадгалагдсанаас агаарт муудсан үнэр тархах	- Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал
Хоёр. Усан орчин			
2.1.	Хатуу болон шингэн хог хаягдал	- Бохир ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал - Хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас хог хаягдал ил задгай хаяснаас	- Хөрс болон хөрсний ус бохирдох магадлалтай. - Хур борооны усаар угаагдаж хөрсний ус бохирдуулна.
Гурав. Хөрс			
3.1.	Элэгдэл, эвдрэл	Явган жим, зам гарах, дагтарших, талхлагдах	- Хэмжээ хязгаарлагдмал - Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөж болно - Хөрс эвдэрч элэгдэж болно. - Нөхөн сэргээх боломжтой.

3.2.	Бохирдол	Ахуйн хог хаягдал	Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар өөрчлөгдөнө.
Дөрөв. Ургамлан бүрхэвч			
4.1.	Ургамлын талхагдал	- Автомашин болон явган хүний зам,мөр - Ашиглалтын талбай, барилга объектуудын орчин	- Хэмжээ хязгаарлагдмал - Ургамлыг нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно.
4.2.	Хордолт	Ахуйн хог болон шатах тослох материалын хаягдал	Ургамлын биомассын хэмжээ багасна - Ургамлан бүрхэвч эргэлт буцалтгүй устаж болно. - Ургамлын генд өөрчлөлт орж болно.
4.3.	Тоосжилт	Бүтээн байгуулалтын үеийн түр хугацааны тоосжилтоос ургамлын фотосинтезийн эрчимтэй буурах	Барилгын явцад тодорхой хугацаанд үргэлжилнэ.
Тав. Ан амьтан			
5.1.	Хордолт	Шатах тослох материалын болон ахуйн хаягдал	Хөрсөн дэх бичил биетэн, шавьж хорхой үрэгдэж болно.
Зургаа. Нийгэм эдийн засгийн орчин			
6.1.	Амрагч, жуулчид	Эдийн засгийн чадавх дээшилнэ	Хүний танин мэдэхүүд дэвшилттэй, соёлыг түгээх зэрэг эерэг нөлөө их
6.2.	Эдийн засаг	Орон нутгийн орлого нэмэгдэх	Улсын төсөвт хувь нэмэр оруулах
6.3.	Ажил эрхлэлт	Ажлын байр шинээр бий болно	Орон нутгийн иргэд ажилтай болох

Хүснэгт 7. Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь

- 2.2 Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь:

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага
Нэг. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт		x								
Газрын доорх усны чанарын өөрчлөлт		x			x			x		
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x						x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x				x	
Геологийн тогтцын өөрчлөлт		x			x					x
Зэрлэг амьтдын орон зай		x		x			x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x		x						x
Хоёр. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг		x			x					x
Бэлчээрийн байдал	x				x		x		x	
Эрдэс түүхий эдийн нөөц		x			x					x
Эрчим хүчний нөөц		x			x		x			
Гурав. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	x				x	x		x		
Урсгал усны хэрэгцээ		x			x				x	

Агаарын бохирдол	x		x	x						x
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x			x					x
Дуу чимээ, шуугианы нөлөө		x			x					x
Дөрөв. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх		x			x					x
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх		x			x					x
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	x						x			x
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх		x			x					x
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх		x			x					x
Тав. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x					x
Орон нутгийн орлого нэмэгдэх		x		x						x
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		x		x						x
Ажлын байр нэмэгдэх	x			x						x
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x			x					x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх										
Зургаа. Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x			x			x		x	
Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс бохирдуулах	x						x		x	
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x		x			x	
Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга	x			x			x	x		
ДҮН	14	17	1	10	17	2	9	3	9	17

Хүснэгт 8. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимтэй нөлөөллийн төрөлтэй уялдах нь

Дээрх нөлөөллийн матрицын тооцооны үр дүнгээс харахад: төслийн байгаль орчинд үзүүлэх нийт 32 нөлөөллийн 14 нь шууд, 17 нь шууд бус, 1 нь өөрөөр зохицуулагдах хэлбэрийн нөлөөлөл байна. Нөлөөллийн үргэлжлэх хугацаагаар нь авч үзвэл ойролцоогоор 34.5%-ийг түр зуурын, 58.6%-ийг богино хугацааны, 6.9%-ийг урт хугацааны нөлөөлөл эзэлж байна. Эрчмийн хувьд нийт 38 тохиолдлын 44.7% нь нөлөөлөлгүй буюу үл мэдэг, 23.7% нь бага, 7.9% нь дунд, 23.7% нь их эрчимтэй нөлөөлөл байгаагаар үнэлэгдлээ. Иймээс төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ голчлон шууд бус, богино

хугацааны боловч зарим тохиолдолд их эрчимтэй нөлөөлөл үзүүлэх чиглэлүүдэд анхаарч, байгаль орчныг хамгаалах болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг БОМТ-ийн дараагийн бүлгүүдэд тодорхойлсон төлөвлөгөөгөөр уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай.

2.3 Нөлөөллийг тодорхойлох арга зүй.

Төслийн байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход ерөнхий үнэлгээний ажлын цар хүрээг цогцоор нэгтгэн нөлөөллийн үнэлгээ, ангилалтай нь хамтатган авч үзлээ. Нөлөөллийг 7 онооны шалгуур бүхий 4 хэсэг болгон дүгнэсэн. Үүнд:

- Нөлөөллийн шинжээр нь эерэг, сөрөг, дунд зэргийн,
 - Нөлөөллийн үр дагаврын оноог байгаль орчны доройтлын байдал, түүний тархалт, хүрээлэн буй орчинд болон байгалийн нөөц, чанарт үзүүлэх эрсдэл зэргийг харгалзсан,
 - Нөлөөллийн цар хүрээ, өртөлтийн хугацаа, байнга буюу түр,
 - Байгалийн нөхөн сэргээгдэх боломж, нөхөн сэргээгдэх байдал.

Нөлөөллийн дүн шинжилгээг суурь судалгааны материал болон судлаачдын мэдлэг туршлагад тулгуурлан хийж гүйцэтгэлээ. Нөлөөллийг оноогоор үнэлэхэд дараах томъёог ашиглав.

Нөлөөллийн нийлбэр оноо = $Cx (Di+S+O+E+Du+R)$. Үүнд:

C – Нөлөөллийн шинж

Di – Доройтол

S – Эрчим

O – Орчинд үзүүлэх эрсдэл

E – Хамрах хүрээ

Du – Үргэлжлэх хугацаа

R – Нөхөн сэргээгдэх чанар

Нөлөөллийн ангилал онооны үнэлгээг доорх хүснэгтэд үзүүлэв. Нөлөөллийн шинж чанар, оноог (-1) сөрөг, (0) дунд зэрэг, эерэг (+1) гэж үзэх ба нөлөөллийн оноо нь 1 (бага)-аас 3 (их) хүртэл байна.

№	Abr	Үзүүлэлт ангилал		Нөлөөллийн оноо	
1	C	Шинж байдал	(1) эерэг	(-1) сөрөг	(0 нөлөөлөлгүй)
2	Di	Үр дагавар	(3) их	(2) байнга	(1) хязгаарлагдмал
3	S	Эрчим	(3) их	(2) дунд зэрэг	(1) бага
4	O	Тохиолдох магадлал	(3) магадлал их	(2) болох магадлалтай	(1) бараг болохгүй

5	E	Хамрах хүрээ	(3) бүс нутгийн хэмжээнд	(2) орон нутгийн хэмжээнд	(1) тодорхой газарт
6	Du	Үргэлжлэх хугацаа	(3) байнга	(2) тодорхой хугацаанд	(1) богино
7	R	Нөхөн сэргээгдэх чанар	(3) нөхөн сэргээгдэхгүй	(2) зарим нөхөгдөнө	(1) бүрэн нөхөн сэргээгдэнэ

Хүснэгт 9. Нөлөөллийн үнэлгээний үзүүлэлт, оноо

2.4 Гол сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

№	Нөлөөлөл	Нөлөөллийн түвшин	Нөлөөллийн үнэлгээ
A	Физик нөлөөлөл	- 11.9	Дунд зэргийн сөрөг нөлөөтэй
A1	Агаарын чанар	- 9	Дунд зэргийн сөрөг
A2	Газрын гадрага, хэвлий	- 13.5	Дунд зэргийн сөрөг
A3	Хөрсөн бүрхэвч	- 13.5	Дунд зэргийн сөрөг
A4	Ус	- 11.6	Дунд зэргийн сөрөг
B	Биологийн олон янз байдал	- 11.6	Дунд зэргийн сөрөг нөлөөтэй
B1	Ургамлан нөмрөг	- 13.6	Дунд зэргийн сөрөг
B2	Амьтны аймаг	- 9.6	Дунд зэргийн сөрөг
C	Нийгэм-Эдийн засгийн нөлөөлөл	+ 6.5	Бага зэргийн эерэг
C1	Ажил эрхлэлт, дэд бүтэц, эдийн засаг	+ 15.5	Их эерэг
C2	Хүний эрүүл мэнд	- 9.6	Бага зэргийн эерэг

Хүснэгт 10. Гол сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Аяан Залаат” аялал жуулчлалын цогцолбор төслийн 2026 оны үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх үндсэн зорилтуудыг Нарийвчилсан үнэлгээний 2025 оны дүгнэлт, 3-р бүлэгт тодорхойлсон нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжлэх хугацааны үнэлгээ болон А/618 тушаалын 3-р хавсралтын шаардлагад үндэслэн тодорхойлов.

2026 онд төслийн байгаль орчны удирдлага, хяналт, хамгааллын үйл ажиллагааг дараах долоон үндсэн зорилтоор хэрэгжүүлнэ.

4.1. Агаарын чанарыг хамгаалах зорилт

Зорилго: Төслийн үйл ажиллагаанаас үүсэх утаа, тоосжилт, дэгдэмхий бодисын нөлөөллийг багасгах, агаарыг бохирдуулах хэмжээг бууруулах.

Гол чиглэлүүд:

- Дулааны зуухны *циклон шүүлтүүрийн* ашиглалтыг хэвийн байлгах, тогтмол засвар үйлчилгээ хийх.
- Барилгын ажлын үеийн тоосжилт багасгах (услан чийгшүүлэх, замын хяналт).
- Автотээврийн хөдөлгөөний тоосжилт бууруулах.
- Хог, бохирын үнэрийн нөлөөллийг бууруулж хадгалалтын дэглэм мөрдүүлэх.

4.2. Усны нөөц, бохир усны менежмент

Зорилго: Гадаргын болон газрын доорх ус бохирдохоос сэргийлэх, хэрэглээг оновчтой болгох.

Гол чиглэлүүд:

- Ахуйн бохир усыг СБОЦБ-ын стандартад нийцүүлэн цэвэршүүлэх.
- Цэвэр усны хэрэглээг оновчтой хязгаарлах, алдагдлын хяналт хийх.
- Борооны усыг гадаргуугаар урсгаж, барилга байгууламж руу чиглэх урсацыг багасгах ус зайлуулах дэд бүтцийг ашиглах.
- Бага ус зарцуулалттай тоног төхөөрөмж, технологи ашиглах.

4.3. Хөрсний хамгаалалт, доройтол бууруулах

Зорилго: Хөрсний элэгдэл, нягтрал, эвдрэл үүсэх эрсдлийг бууруулах.

Гол чиглэлүүд:

- Явган болон тээврийн хөдөлгөөнөөс үүсэх талхагдалд хяналт тавих.
- Эвдэрсэн хөрсний нөхөн сэргээлтийг үе шаттайгаар хийх.
- Ахуйн болон барилгын хогийг ил задгай хаяхгүй байх, хяналттай хураах.
- Гулгалт, уруйн эрсдэлтэй газарт хөрсний хамгаалалтын инженерийн арга (шороон далан, шуудуу, суваг, чиглүүлэгч байгууламж) хэрэглэх.

4.4. Ургамал, амьтны аймгийн хамгаалалт

Зорилго: Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд орших эмзэг экосистемд нөлөөлөх байдлыг бууруулах.

Гол чиглэлүүд:

- Ургамлын бүрхэвч талхагдахаас сэргийлэх, ногоон байгууламжийг нөхөн сэргээх.
- Амьтдын үргээлт, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх дуу чимээ, гэрэлтүүлгийн нөлөөг бууруулах.
- Хамгаалалттай ургамлын зүйлийн бүртгэлийг хадгалах, гэмтэл гарсан тохиолдолд мэдээлэх.
- Ойн зурвасыг гэмтээхгүй, мод огтлохгүй байх дэглэм мөрдөх.

4.5. Хог хаягдлын менежмент

Зорилго: Хатуу болон шингэн хог хаягдлаас үүдэх хөрс, ус, агаарын бохирдлоос сэргийлэх.

Гол чиглэлүүд:

- Ангилан ялгалтын системийг хэрэгжүүлэх (хогны 4 төрөл).
- Аюултай хог хаягдлын хадгалалт, тээвэрлэлт, тушаалтыг MNS 6458-д нийцүүлэх.
- Хоолны хаягдал, үнэрт хогийг өдөр бүр зайлуулах.
- Ил задгай хог гаргахгүй байх, жуулчны бүсийн цэвэрлэгээг тогтмол хийх.

4.6. Осол, эрсдэлийн удирдлага

Зорилго: Гал түймэр, газар хөдлөлт, уруйн ус, амьтны дайралт зэрэг эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах.

Гол чиглэлүүд:

- Галын аюулгүй байдлын төлөвлөгөө, гарцаа 3 байршлаар шинэчлэх.
- Уруйн усны эрсдэлийн улирлын судалгаа, хамгаалалтын далангийн шалгалт.
- Зэрлэг амьтны халдлагаас хамгаалах хашаа, гэрэлтүүлгийг сайжруулах.

- Онцгой байдлын үед нүүлгэн шилжүүлэх журам мөрдөх.

4.7. **Нийгэм-эдийн засгийн нөлөөлөл, оролцогч талууд**

Зорилго: Орон нутгийн оршин суугчид, байгууллагуудтай уялдаатай, эерэг нөлөөлөлтэй үйл ажиллагаа явуулах.

Гол чиглэлүүд:

- Ажлын байрны харилцаа, хөдөлмөрийн стандарт мөрдүүлэх.
- Байгальд ээлтэй аялал жуулчлалын соёлыг төлөвшүүлэх.
- Орон нутгийн байгууллагуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах.
- БОМТ-ийн хэрэгжилтийг жил бүр тайлагнах (А/618 дагуу).

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

СӨРӨГ НӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
№	Гол болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт
Нэг. Агаарын чанар						
1	Хүйтний улиралд уурын зуухнаас гарах CO, CO2 SO2, NO2 ихсэх, үйлчлүүлэгч иргэд, аялагчдын автомашины хөлөөр үүсэх тоосжилт, утаа тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчныг бохирдуулах, ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас ойр орчинд үнэр тархах	Орчны тоосжилт болон салхины хурд, дуу чимээг бууруулах болон салхинаас хамгаалах зорилгоор мод бут тарина.	Төслийн хүрээнд	Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд туссан	2026 оны 06 дугаар сар	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2023, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ
2		Тоосжилт бууруулах зорилгоор төв зам хүртэлх замыг хатуу хучилттай болгох хайрга чулуу дэвсэ	Төслийн хүрээнд	Хөрөнгө оруулалтын зардалд туссан.	2025 оны 09 дүгээр сард хөрөнгө оруулалтын зардлаар хэрэгжүүлсэн	
3		Уурын зууханд агаарын бохирдлын /CO, CO2 SO2, NO2, Тоос/ шинжилгээ хийлгэнэ.	Төслийн хүрээнд	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардалд туссан.	2026 оны 03, 06, 09, 12 дугаар сар	
4		Тээврийн хэрэгслийн хурдны хязгаарлалт, зам талбай, зогсоолын тэмдэг, тэмдэглэгээ, анхааруулгыг байршуулна.	Төслийн хүрээнд	1,500.0	2026.09 дүгээр сар	
5		Нүүрсээр ажилладаг уурын зуухыг байгаль орчинд ээлтэй газар зуухаар үе шаттайгаар шилжүүлэх арга хэмжээг тухайн жилийн менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, шилжилтийн хугацаанд уурын зуухны ажиллагааг хэвийн горимд ажиллуулан бүрэн шаталтыг хангаж, дутуу шаталт болон агаар	Төслийн хүрээнд	Хөрөнгө оруулалтын зардалд туссан.	2026.06 сараас 2026.10 сар	

		бохирдуулагч бодисын ялгаралтыг бууруулна.				
6		Ахуйн хог хаягдлыг ялган ангилах цэг байгуулж, аюултай болон ахуйн хаягдлыг тус тусад нь цуглуулан, эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж, тогтмол тээвэрлүүлэн зайлуулах, хог хадгалах савны битүүмжлэлийг хангаж үнэр тархалтыг бууруулна.	Төслийн хүрээнд	Хөрөнгө оруулалтын зардалд туссан.	2026 оны 10 дугаар сар	
Хэсгийн дүн			1,500.0			
Хоёр. Усан орчин						
7	Төслийн барилгажилтын үе шатанд /цэвэр, бохир усны шугам/ гадаргын болон гүний усанд нөлөөлөх, Шатах тослох материалыг алдсанаар	Цэвэр, бохир ус дамжуулах шугамын холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг хянах, тухай бүр нэн даруй засвар хийнэ.	Төслийн хүрээнд	1,000.0	2026 оны 01–12 дугаар сар, сар бүр	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS4586-98 (CXЗҮТ, 1998.5.28-ны өдрийн 17 тоот тогтоол.), Усан орчны чанарын хяналт шинжилгээ MNS4047-88 (УСТ-ын даргын 1988 оны 248 тоот тушаал), Усны чанар, хаягдал бохир ус. MNS 4943-2015 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль
8	газрын доорх ус бохирдох, Бохир ус дамжуулах шугам	Үйл ажиллагаанд хэрэглэх усны зарцуулалтад тогтмол хяналт тавьж, усыг хэмнэлттэй хэрэглэнэ.	Төслийн хүрээнд	1,000.0	2026 оны 01–12 дугаар сар, сар бүр	
9	хоолойг зориулалтын бус материалаар хийх, шугам хоолойд гэмтэл үүсэж гүний усыг бохирдуулж болзошгүй. Усны эх үүсвэрийн хомсдол үүсэх	Гүний худгийн усны түвшин, ашиглалтын байдалд тогтмол хяналт тавьж, усны гарц буурсан тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэн шаардлагатай арга хэмжээг авна.		10,000.0	2026 оны 10–11 дугаар сар	
Хэсгийн дүн			12,000.0			

Гурав. Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг						
10	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс байгууламжуудын дор дарагдаж, зам тээвэр, бүтээн байгуулалт болон бусад үйл ажиллагаатай холбогдож элэгдэл, эвдрэлд өртөнө. Барилгын ажлын улмаас хаягдлаар хөрс бохирдоно.	Төслийн талбайн шимт өнгөн хөрсийг төсөл эхлэхээс өмнө хуулж овоолон дараа нь нөхөн сэргээхэд ашиглах	Төслийн хүрээнд	3,000.0	2026 оны 01–12 дугаар сар, сар бүр	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль. MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5918:2023 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага
11		Автомашины тос, бензин хөрсөн бүрхэвчийг бохирдуулахаас хамгаалах	Төслийн хүрээнд	1,000.0	2026 оны 03, 06, 09, 12 дугаар сар	
12		Төслийн автомашин зорчих маршрутыг төлөвлөж, зорчих зам болон зогсоолын талбайг тэмдэгжүүлэх	Төслийн хүрээнд	2,500.0	2026.09 дүгээр сар	
13		Эвдрэлд орсон талбайд стандартын дагуу хэлбэржүүлж, нөхөн сэргээх, ургамалжуулах, ногоон байгууламж, зүлэгжүүлэлт, мод бүхий зурвас байгуулах	Төслийн хүрээнд	Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд туссан	2026 оны 06 дугаар сар, 05-10 сар хүртэл тогтмол хяналт	
Хэсгийн дүн				6,500.00		
Дөрөв. Амьтны аймаг						

14		Барилга байгууламж барихдаа ТХГН-ын тухай хууль болон ДЦГ-ын бүсийн дэглэм болон хориотой үйл ажиллагааны заалтуудыг чанд мөрдөн ажиллах	Төслийн хүрээнд	-	2026 оны 06 сар	MNS 6426:2013 “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” Монгол Улсын стандартын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөх
15	“Барилга барих үйл ажиллагаа нь ТХГН ба ДЦГ-ын дэглэмийг зөрчсөн тохиолдолд газрын төлөв байдлыг доройтуулах, эко системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх, үүсгэх	“Газар ашиглалтын нөхцөл мөрдөлтийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор жилд 1 удаа хяналт-шинжилгээ хийж, үр дүнгийн тайлан боловсруулан баталгаажуулна.”	Төслийн хүрээнд	-	2026 оны 11 сард	
16		Замын тэмдэгтүүд, ялангуяа байгаль орчныг хамгаалах, ТХГН-тай холбоотой /ДЦГ/ сурталчилгааны самбар, сануулгыг хийж байрлуулах шаардлагатай.	Төслийн хүрээнд	2,500.0	2026 оны 09 сард	
Хэсгийн дүн				2,500.0		
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ				22,500.0		

Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө

ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЦОГЦОЛБОРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ						
№	Гол болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт
Нэг. Ногоон байгууламж						
1	Төслийн үйл ажиллагаанаас цогцолборын орчмын газрын гадарга, дэд бүтэц, бусад дагалдах байгууламж элэгдэл, эвдрэлд өртөх	Тус компани нь жилд Гацуур 44 ш, Нарс 69 ш, Шар хуайс 157 ш, нийт 270 ш модлог ургамал, нийтийн хэрэгцээний ногоон байгууламжид 4205м2 талбай, хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжид 5000м2 талбайд зүлэгжүүлэлт хийхээр төлөвлөсөн.	Төслийн хүрээнд	33,956.0	2026 оны 06 сар	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль. MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5918:2023 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага
Хэсгийн дүн				33,956.0		

Хүснэгт 12. Цогцолборын нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар археологийн болон палеонтологийн судалгааг хийлгэсэн ба тухайн судалгаагаар олдвор илрээгүй. Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т, Газрын хэвлийн тухай хуулийн 43.2-т тус тус заасны дагуу үйл ажиллагаагаа зогсоож нэн даруй холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлж, олдворыг хамгаалалтад авах

үүрэгтэй. Нийт ажиллагсдад компанийн “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-танилцуулсан бөгөөд цаашид дагаж мөрдөж ажиллана.

ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгж	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Соёлын өвийн зааварчилгаа	Төслийн талбай	Газар шорооны ажилд оролцох хүн	-	2026 оны 07 дугаар сар	Соёлын өвийн тухай хууль
Түүх соёлын дурсгалт газруудад ажиглалт мониторинг хийх	Төслийн талбай,түүний орчимд	Дурсгалт газар	-	2026 оны 11 дугаар сар	
Төслийн талбайд шинээр газар хөндөх ажилд соёлын өвийн хайгуул, авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулах	Төслийн талбай	Газар шорооны ажил хийх талбай	-	2026 онд шинээр газар хөндөхгүй	

Хүснэгт 13. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

НАЙМ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн бүхий л үе шатанд тохиолдож болзошгүй осол, аюул, эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгав. Осол, аюулыг эх үүсвэрээр нь дараах байдлаар ангилав. Үүнд:

1. Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад үүсэх осол,
2. Мэргэжлээс шалтгаалах өвчлөл, халдварт өвчин тархалтаас шалтгаалсан осол,
3. Аюултай бодис асгарах,

4. Байгалийн гамшиг тохиолдох,
5. Гал түймэр гарах,
6. Хяналтаас гадуурх дэлбэрэлт үүсэх,
7. Хаягдал хадгалах байгууламжийн далан нурах, хаягдлын зуурмагийн дамжлага эвдрэх,
8. Тээврийн хэрэгслийн осол гарах.

ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ					
№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Нийт төсөл хэрэгжих талбай, барилга байгууламжид	500.0	2026 оны 01–12 дугаар сар, сар бүр	Гамшгаас хамгаалах тухай хууль, “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”
2	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	1,000.0	2026 оны 04 дүгээр сар	
3	Үерийн хамгаалалтын нам болон өндөр даланг байгуулж, жалга, суваг шуудуу руу урсахаар засаж тохижуулах	Төслийн талбай орчим	Хөрөнгө оруулалтын зардалд туссан	2026 оны 05 дугаар сар	
4	Хамгаалалтын далан, жалга сайрыг цэвэрлэж байх	Төслийн талбай орчим	300.0	2026 оны 03, 06, 09, 12 дугаар сар	
5	Өөрийн байгууламжид үер усны аюул, гал түймрээс урьдчилан сэргийлэх тусгай бүдүүвч схем боловсруулан ажиллах	Төслийн хүрээнд	200.0	2026 оны 07 дугаар сар	
6	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Төслийг бүхэлд нь	500.0	2026 оны 03, 06, 09, 12 дугаар сар	
Нийт			2,500.0		

Хүснэгт 14. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө. Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/ хуульд заасан хог хаягдлын талаар аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг биелүүлэн ажиллана.

		ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ				
№	Хүрээлэн буй орчин	Хэрэгжүүлэх үндэслэл, шаардлага	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Жилд зарцуулах зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	Хог хаягдлын цэг, ангилан ялгах талбай, оффис, ажилчдын сууц, гал тогоо орчим бохирдол үүсэж болзошгүй тул хог хаягдлын талаар хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах	Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах	3,000.0	2026 оны 10 сар	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон холбогдох тогтоол, дүрэм, журам
2			Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, үүссэн хог хаягдлаа тогтмол зайлуулах	-	2025 оны 07 сард хийсэн жил бүр сунгаад явна.	
3			Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлахдаа эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх, устгах	-	2026 оны 10 сар	
4			Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах	1,000.0	2025 оны 08 сард хийсэн жил бүр сунгаад явна.	
5			Үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгахдаа үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	-	2025 оны 08 сард хийсэн жил бүр сунгаад явна.	
НИЙТ ЗАРДАЛ				4,000.0		

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

АРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТ

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ						
№	Хүрээлэн буй орчин	Хэрэгжүүлэх үндэслэл, шаардлага	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Жилд зарцуулах зардал /мян.төг/	Хугацааны ба давталт	Баримтлах стандарт, аргачлал
1	БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ	Байгаль орчны хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт	Төслийн үйл ажиллагаанд нийцлийн аудит хийх	БОННУ-нд тусгасны дагуу төлөвлөгөөт байгаль орчны аудит 2027 онд хийгдэнэ.”	2026 онд хийгдэхгүй	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 101 дэх заалт, “Байгаль орчны аудит хийх эрх олгох журам, байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/809 тоот тушаал
НИЙТ ЗАРДАЛ			Байгаль орчны аудит хийх зардал туссан дүн		0.0	

Хүснэгт 16. Байгаль орчны төлөвлөгөөт аудит

АРВАН НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн хэрэгжилтийн хугацаанд байгаль орчныг хамгаалах, зөв зохистой ашиглах, сөрөг нөлөөллийг бууруулах үүргийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага хуулийн дагуу хүлээнэ. Энэхүү үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон түүний бүрэлдэхүүн хэсэг болох Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсруулан мөрдөх шаардлагатай.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд гарч болох өөрчлөлтүүдийг тогтмол хянах, үнэлэх, сөрөг нөлөөний эрчмийг багасгах арга хэмжээний үр дүнг баталгаажуулах үндсэн зорилготой. Хөтөлбөрт хяналт тавих үзүүлэлт, тэдгээрийн байршил, давтамж, шинжилгээ хийх аргачлал, баримтлах стандарт, шаардлагатай зардлыг нарийвчлан тусгана.

Хяналт шинжилгээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, стандарт, аргачлалын шаардлагыг баримталж ажиллана. Хууль, стандарт шинэчлэгдсэн тохиолдолд шинэчилсэн хувилбарыг дагаж мөрдөнө. Хөтөлбөрийн үр дүн нь:

1. Таамагласан болон бодит сөрөг нөлөөллийн зөрүүг тодорхойлох,
2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшинг үнэлэх,
3. Сөрөг нөлөөллийн эрчимтэй нэмэгдэж байгаа эсэхийг илрүүлэх,
4. Менежментийн үр ашгийг дүгнэхэд ашиглагдана.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР					
№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ, хугацаа	Нэгжийн өртөг, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Нэг. Агаарын чанар					
1	Ялгарах бохирдуулагчид: SO ₂ , CO, NO ₂	Төслийн талбайд 5 байршилд	2026 оны 03, 06, 09, 12 сард	1,000.0	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага (MNS 4585:2016), MNS 5919:2008 Дулааны

2	O2, CO2, CO, NO, NO2, SO2, CxHy/HC, H2S, утааны хэм OC, утааны агаарын даралт, утааны хурд м/с	Уурын зуух	2026 оны 03, 06, 09, 12 дугаар сар	1,500.0	цахилгаан станцын агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5013:2001 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ MNS ISO 4221: 2002 Агаарын чанар. Орчны агаарын хүхрийн давхар
3	Тоосны хэмжилт: PM10, PM2.5, Тоосны чөлөөт Уналт Тоосны найрлага, бүтэц Тоосны тархалт	Төслийн талбайд 5 байршил	2026 оны 03, 06, 09, 12 дугаар сард	1,000.0	
Нийт				3,500.0	
Хоёр. Газрын доорх ус					
4	Химийн ерөнхий шинжилгээ, Хүнд металлын агууламж Ca, Mg, Cl, SO4, NO2, NO3, NH4, HCO3, Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca-ийн агууламж, амт, үнэр, өнгө, pH, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар, усны түвшин Микробиологи	Нийт 1 цэг, цаашид усны эх үүсвэр шинээр байгуулсан тохиолдолд нэмж тусгана.	Төслийн үйл ажиллагааны эхний 5 жилд улиралд нэг удаа (газрын доорх усны чанарын өөрчлөлтөөс шалтгаалан давтамжийг өөрчилж болно), 2026 оны 03, 06, 09, 12 дугаар сар	1,000.0	MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт MNS (ISO) 5667 11:2000 Усны чанар Дээж авах: 11-р хэсэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж MNS (ISO) 5667-1:2002 Усны чанар-Дээж авах: 1-р хэсэг. Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар
Нийт				1,000.0	
Гурав. Хөрсөн бөрхөвч					
5	Хөрсний орчин /Ялзмагийн агууламж мг/кг, Карбонатын агууламж, Хөрсний ширхгийн бүрэлдэхүүн/ Хүнд металлын агууламж	Төслийн талбай орчимд 4 цэгт, Нөлөөлөлд өртөөгүй буюу харьцуулах хяналтын 2 цэгүүдэд	2025-2029 он хүртэл жилд 1 удаа буюу 7-8 сард хийнэ. Цаашид ургамлан нөмрөгийн мониторингийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс шалтгаалан давтамжийг өөрчлөх	2,000.0	MNS:3297:1991 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ. MNS:2305:1994 Хөрсний дээж авах, савлах, тээврлэх хадгалах журам MNS:3298:1991 Хөрсний шинжилгээнд дээж авах тавигдах ерөнхий зарчим. Хөрсний дээжийг нарийвчлал өндөртэй AAS зэрэг багажит анализын аргаар хяналтын СП ашиглан давталттай шинжлүүлэх. Шинжилгээний дүнг үндэсний стандарт болон ОУ-ын стандарттай жишиж дүгнэлт гаргах
Нийт				2,000.0	

Дөрөв. Ургамлан нөмрөг					
6	Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл), Бодгалийн тоо Дундаж өндөр, см Бүрхэц, % Фенелогийн үе шат Биомасс, цн/га Ургамлын үрийн банк Ургамлын нягтшил 1м2/бодгаль, Тоосжилтын нөлөө	Төслийн талбай н орчимд 5 цэгт, нөлөөлөлд өртөөгүй буюу харьцуулах хяналтын 2 цэгт	2025-2029 он хүртэл жилд 1 удаа буюу 7-8 сард хийнэ . Цаашид ургамлан нөмрөгийн мониторингийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс шалтгаалан давтамжийг өөрчлөх	2,000.0	Мониторингийн цэг бүрт судалгааг 25х 25 м2 талбайд 1 удаагийн давталттайгаар хийх, Мониторингийн судалгааны өмнө тухайн бүлгэмдэл болон талбайн фото зургийг авч баримтжуулах, Тухайн мониторингийн цэг нь ямар бүлгэмдэлд хамаарагдаж буйг тодорхойлох, 1х1 м талбайд: Бүрхэцийг тусгагийн аргаар үнэлэх, Зүйл бүрийг бүртгэх,
Нийт				2,000.0	
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ				8,500.0	

Хүснэгт 17. Цогцолборын нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч
Агаарын чанарын менежмент			
1	Дулааны зуухны шүүлтүүрийн хяналт, үйлчилгээ	Сар бүр	ИТА
2	Тоосжилт бууруулах (усалгаа, замын хяналт)	Барилгын үе /улирлаар/	Барилга төсөл
3	Агаарын чанарын хэмжилт	Хөтөлбөрийн дагуу	Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын алба /Мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ/
Усны нөөц, бохир усны менежмент			
4	Бохир ус цэвэрлэх байгууламжийн үзлэг	Сар бүр	ИТА
5	Гүний худгийн түвшин, чанарын хяналт	Улирал бүр	ИТА, Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын алба /Мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ/
6	Бороо, гадаргын усны урсгалын хяналт	Улирал бүр	ИТА
Хөрсний хамгаалалт, нөхөн сэргэлт			
7	Нөхөн сэргээх ажлын гүйцэтгэл	Хавар, намар	Мэргэжлийн байгууллага
Биологийн олон янз байдал (ургамал, амьтан)			

8	Ургамлын мониторинг	Жилд 1 удаа	Байгаль орчны мэргэжлийн байгууллага
9	Амьтдын шилжилт хөдөлгөөний ажиглалт	Улирал бүр	Аюулгүй байдлын алба
Хог хаягдлын менежмент			
10	Ангилан ялгалт, цэвэрлэгээ	Тогтмол	Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын алба /Мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ/
11	Хог тээвэрлэлтийн компаниар ачилтыг гүйцэтгүүлэх	Төлөвлөгөөт хугацаанд	Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын алба /Мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ/
Осол, эрсдэлийн удирдлага			
12	Гал түймрийн сургалт	Жилд 1	Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын алба /Мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ/
13	Үер, салхи, амьтны эрсдэлийн шалгалт	Улирал бүр	Аюулгүй байдлын алба
Байгаль орчны хяналт-шинжилгээ			
14	Агаарын шинжилгээ	Улиралд 1 удаа	Гадаад лаборатори
16	Усны шинжилгээ	Улиралд 1 удаа	Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын алба /Мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ/
17	Хөрсний шинжилгээ	Улиралд 1 удаа	Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын алба /Мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ/
18	Ургамлын мониторинг	Жилд 1 удаа	Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын алба /Мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ/

АРВАН ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцах эзэн
1	Төрийн захиргааны төв байгууллага /БОУАӨЯ/	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тайлагнах, батлуулах	Төсөл хэрэгжүүлэгч
2	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн сум багийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах		Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Төсөл хэрэгжүүлэгч
3	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн бүх шатны Засаг дарга	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж тайланг хүргүүлэх		Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Төсөл хэрэгжүүлэгч

АРВАН ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ НИЙТ ЗАРДАЛ

№	Менежментийн төлөвлөгөө	Зардлын хэмжээ, мян.төг
1	Сөрөг нөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	22,500.0
2	Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	33,956.0
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,500.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4,000.0
5	Байгаль орчны аудит	0.0
6	Байгаль орчны хяналтын шинжилгээний хөтөлбөр	8,500.0
	НИЙТ ДҮН	71,456.00